



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/368

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд Орон нутгийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогоор илэрсэн бүртгэлд тусгаагүй, маргаантай хөрөнгүүдэд хяналт тавих, зөвлөн туслах чиглэлээр сумдад ажиллах, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас аймгийн орон нутгийн өмчийн газарт 5 хоногийн хугацаанд ажил шалгах, зөвлөн туслах ажлыг зохион байгуулж ажилласантай холбогдуулан гарсан зардалд 2.574.400 (хоёр сая таван зуун далан дөрвөн мянга дөрвөн зуу) төгрөг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 2,574,400 (хоёр сая таван зуун далан дөрвөн мянга дөрвөн зуу) төгрөгийг “Эрх зүй нийгмийн хэв журам” хөтөлбөрийн Засаг даргад хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6712011116 Захирамж2024